



“ АРИГ ГАЛ “
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 дугаар
сарын 19- ны өдөр

Дугаар 14 /20

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай:

Монгол Улсын “Компанийн тухай хууль”- ийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, түүнд СЗХ-ны 2021 оны 45 тоот тогтоолоор оруулсан нэмэлт өөрчлөлтийн холбогдох заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.“Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04-р сарын 30-ны өдрийн 17 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 19-р хороо, Үйлдвэрийн парк-1 хаягт байрлах компанийн байр. Хурлын танхимд хуралдуулсугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

2.1 Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнгийн талаарх гүйцэтгэх захирлын тайланг хэлэлцэж батлах;

2.2 Компанийн 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

2.3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

2.4. 2020 оны үйл ажиллагааны үр дүнгээр хуваарилах ногдол ашгийн хувь хэмжээг тогтоосон ТУЗ-ийн хурлын 2021 оны 2 сарын 10-ны өдрийн 14.20 тоот шийдвэрийг хэлэлцэж батламжлах.

2.5 АГ ХК-ийн ХЭХ-ын болон ТУЗ-ийн үйл ажиллагааны 2021 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах

2.6 “Ариг гал” ХК-ийн ТУЗ-өөс гаргасан охин компанид оруулах хөрөнгө оруулалтыг биет хөрөнгөөр нэмэгдүүлэх тухай 2020 оны 08.20 болон хөрөнгийн эх үүсвэр гаргах тухай 10.20 тоот шийдвэрүүдийг танилцуулах тухай

3.Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо МХБ-д мэдэгдэх өдрийг 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2021 оны 3 дугаар сарын 25 болон 4 дүгээр сарын 09-ний өдрүүдээр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөр тогтоосугай.

5.Хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хурлын материалыг 2021 оны 3 сарын 30 дотор хүргүүлэх, эхний болон давтан зарыг өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Дараах бичиг баримтуудыг компанийн байр болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд:

6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар;

6.2. Хурлаар хэлэлцэх асуудлуудаар гарах шийдвэрийн үндэслэл болох үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;

6.3.Хурлын санал хураах хуудас.

6.4 ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийн тухай танилцуулга

6.5 ТУЗ-ийн болон ХЭХ-ын 2021 оны зардлын төсөв

6.6 Ххувьцаа эзэмшигчдэд 2020 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан тухай ТУЗ-ийн 12/20 тоот тогтоолыг ХЭХ-аар хэлэлцүүлж дэмжүүлэх

6.7 гаргасан охин компанид оруулах хөрөнгө оруулалтыг биет хөрөнгөөр нэмэгдүүлэх тухай 2020 оны 08.20 болон хөрөнгийн эх үүсвэр гаргах тухай 10.20 тоот тогтоолын танилцуулга

7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр баталсугай.

8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2021 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 12 цагаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Гиваапийг, хурлын тооллогын комиссын даргаар Ч.Энхцэцэгийг томилсугай.

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга материал, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /Д.Гиваапил/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

С.МӨНХЖАРГАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Б.БОЛД

Б.АЮУШ

Б.ЁНДОНЖАМЦ

Э.БЯМБАЖАВ

Д.ГИВААПИЛ

С.АЛИМАА

Д.МӨНХБАТ